



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/118/СТА-ТШЗ

Баянхонгор  
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576      Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024      Цахим хаяг: [tsetsegmaadam@audit.gov.mn](mailto:tsetsegmaadam@audit.gov.mn)

Аудитор:              Ж.Өсөхбаяр

Утас: 99890393      Цахим хаяг: [usukhbayar\\_j@yahoo.com](mailto:usukhbayar_j@yahoo.com)

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал .....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН НОМГОН  
АХЛАХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.САРАНГЭРЭЛ ТАНАА 7

2019.02.25 № 2/82  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Аудитын гол асуудал

E:\Usukhuu\STA-2019\4.Номгон ахлах сургууль\4.Тайлагнал\Номгон\_Гэрчилгээ.docx

2519149

Тайлант онд цалингийн санг Нийгмийн даатгалын хэлтэст 8080.2 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн, ажилчдад олгосон цалингийн урьдчилгаа 1730.4 мянган төгрөгийг суутган тооцоогүй, ажилчдад олгох цалинг зөрүүтэй тооцоолсноос 75.0 мянган төгрөг илүү олгож тус тус авлагаар бүртгээгүй, мөн цалин бодохдоо суутгалыг гарт олгох цалингаас илүү дүнгээр суутгаж цалингийн цэст хасах дүнтэй гарсан зэргээр НББ-ийн стандарт бус бичилт хийсэн зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагуудад мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн дасны заавар"-ын 3.5. "Төсвийн зардлыг одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомж, сангийн яамнаас гаргасан дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилан бүртгэнэ", 3.6. "Тайлангийн хугацааны цалингийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ" гэсэн заалтууд болон УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-ийг зөрчиж санхүүгийн тайлангийн "Үнэлгээ", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp is placed over a handwritten signature. The stamp contains Mongolian text: "Санхүүгийн аудит", "УСНББОУС 1", and "БНА-2019/118/СТА-ТШЗ". The signature is written in black ink over the stamp.

Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Л.Сарангэрэл-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор сумын Номгон ахлах сургууль нь “Багшийн ёс зүйг эрхэмлэн, хүүхэд бүрийн сурах, хөгжих идэвх оролцоог дэмжиж сургалт хүмүүжлийн ажлын чанарт ахиц гаргана” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багшийн ёс зүйг эрхэмлэн дээдэлж, хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжин сургалт хүмүүжлийн ажлын чанарт ахиц гаргах

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2332438.5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 46648.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

### Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	8080.2	
2	Төлбөрийн акт тогтоосон	3	2478.3	
	Дүн	4	10558.5	

### **2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### **2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал**

Тайлант онд 5 ажилтнаас 1730449 төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй нь “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

#### **2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал**

Тайлант онд Ё.Цолмонд 2018 оны 1,2,3 дугаар саруудад тус тус 25000 төгрөгийг цалингийн цэстээр гарт олгох цалин дээр нэмж олгосон нь “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

#### **2.8.1.3 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

Утасны төлбөр 672,9 мянган төгрөгийг ажилчдаас суутгаагүй атлаа цалингийн зардлаас шилжүүлсэн нь “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1902983.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1901175.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь 2018 онд 1898883.3 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 636.5 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39 гүйлгээг хугацаанд нь тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.2 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Цалингийн санг нийгмийн даатгалын хэлтэст мэдээлэхдээ 8080.2 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн нь “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

##### **3.2.2 Эрсдэл:**

Зардал буруу илэрхийлэгдэх

##### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>87,970,336.90</b>	<b>106,399,099.69</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	35,189.08	7,824,751.87
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	35,189.08	7,824,751.87
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	87,935,147.82	98,574,347.82
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	169,700.00	245,400.00
35130	Эм боох материал	169,700.00	245,400.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11,670,700.00	11,670,700.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	76,094,747.82	86,658,247.82
35410	Бичиг хэргийн материал	1,084,500.00	1,171,000.00
35420	Аж ахуйн материал	468,880.00	556,880.00
35440	Түлш, шатах тослох материал	00.32	00.32
35450	Барилгын засварын материал	1,168,423.00	2,087,423.00
35470	Бусад хангамжийн материал	73,372,944.50	82,842,944.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,895,944,538.76</b>	<b>3,083,691,487.03</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,895,944,538.76	3,083,691,487.03
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,895,944,538.76	2,211,116,487.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,055,384,623.85	2,074,238,564.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,345,031,585.29	-44,427,253.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	499,701,675.02	518,248,545.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	-384,970,064.69	-426,284,578.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	109,207,635.27	132,778,135.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	-83,365,075.52	-90,852,655.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	44,712,330.12	47,110,730.12
39217	Ном	305,000.00	305,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	872,575,000.00
39301	Програм хангамж	5,878,998.00	5,878,998.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,878,998.00	-5,878,998.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	872,575,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,983,914,875.66</b>	<b>3,190,090,586.72</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>56,045.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	56,045.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	56,045.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	43,945.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	12,100.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	100.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	12,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,983,858,830.66</b>	<b>3,190,090,586.72</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,983,858,830.66	3,190,090,586.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,626,130,779.83	2,498,705,779.83
51101	Өмч: - төрийн	1,626,130,779.83	2,498,705,779.83
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-2,141,220,230.37	-2,464,035,496.44
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,141,220,230.37	-2,141,220,230.37
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-322,815,266.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,498,948,281.20	3,155,420,303.33
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,983,914,875.66</b>	<b>3,190,090,586.72</b>

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,131,442,621.00</b>	<b>2,009,623,310.30</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,007,470.00</b>	<b>37,339,430.60</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,007,470.00	37,339,430.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,007,470.00	37,339,430.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,101,400.00	2,928,260.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,906,070.00	34,411,170.60
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>68,525,651.00</b>	<b>73,400,579.70</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,044,909,500.00	1,898,883,300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,800,000.00	38,320,286.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,800,000.00	38,320,286.70
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	31,296,931.00	00.00
133003	Хөрөнгийн	31,296,931.00	00.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	30,428,720.00	35,080,293.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	30,428,720.00	35,080,293.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,368,222,457.55</b>	<b>2,201,352,975.80</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,368,222,457.55</b>	<b>2,201,352,975.80</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,944,056,098.81	2,001,478,795.80
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,247,871,268.03	1,218,429,336.00
210101	Үндсэн цалин	1,019,461,376.03	964,218,748.00
210102	Нэмэгдэл	160,480,992.00	182,254,989.00
210104	Урамшуулал	67,928,900.00	71,955,599.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	132,077,500.00	156,907,630.00
210201	Тэтгэврийн даатгал	132,077,500.00	156,907,630.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	262,364,400.00	332,248,400.00
210301	Гэрэл, цахилгаан	12,512,128.00	14,137,600.00
210302	Түлш, халаалт	230,380,302.00	282,985,385.00
210303	Цэвэр, бохир ус	19,471,970.00	35,125,415.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,315,549.00	14,758,336.00
210401	Бичиг хэрэг	6,858,849.00	7,291,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,371,700.00	1,118,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,357,832.00	2,465,516.00
210404	Ном, хэвлэл	174,000.00	32,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,246,068.00	3,850,020.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	307,100.00	00.00
2105	<b>Нормативт зардал</b>	953,650.00	169,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	953,650.00	169,700.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,783,950.00	4,502,000.00
210604	Урсгал засвар	12,783,950.00	4,502,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,009,200.00	611,000.00
210702	Дотоод албан томилолт	1,009,200.00	611,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,117,000.00	13,541,886.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,117,000.00	13,541,886.70
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	266,563,581.78	260,310,507.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,356,400.00	3,030,263.21
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	301,766.00	2,550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	262,905,415.78	254,730,243.89
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	424,166,358.74	199,874,180.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	424,163,911.00	199,237,643.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	30,428,720.00	35,080,293.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	95,700,400.00	101,365,850.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	126,009,700.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	169,235,091.00	61,791,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,790,000.00	1,000,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,447.74	636,537.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,447.74	636,537.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-236,779,836.55</b>	<b>-191,729,665.50</b>
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	897,400.00	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	897,400.00	00.00
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	131,085,600.57
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	927,596.11
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	130,158,004.46
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	897,400.00	-131,085,600.57
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-235,882,436.55</b>	<b>-322,815,266.07</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,087,239,620.00</b>	<b>1,975,212,139.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,101,400.00</b>	<b>2,928,260.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,101,400.00	2,928,260.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,101,400.00	2,928,260.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,101,400.00	2,928,260.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>2,082,138,220.00</b>	<b>1,972,283,879.70</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,044,909,500.00	1,898,883,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,800,000.00</b>	<b>38,320,286.70</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,800,000.00	38,320,286.70
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,428,720.00</b>	<b>35,080,293.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	30,428,720.00	35,080,293.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,087,239,620.00</b>	<b>1,975,212,139.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,087,239,620.00</b>	<b>1,975,212,139.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,625,020,261.26</b>	<b>1,775,337,959.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,178,687,499.26</b>	<b>1,224,523,837.00</b>
210101	Үндсэн цалин	950,277,607.26	970,343,248.00
210102	Нэмэгдэл	160,480,992.00	182,224,989.00
210104	Урамшуулал	67,928,900.00	71,955,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>132,077,500.00</b>	<b>152,280,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	132,077,500.00	152,280,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>262,364,400.00</b>	<b>332,248,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,512,128.00	14,137,600.00
210302	Түлш, халаалт	230,380,302.00	282,985,385.00
210303	Цэвэр, бохир ус	19,471,970.00	35,125,415.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,430,002.00</b>	<b>9,933,336.00</b>
210401	Бичиг хэрэг	3,066,250.00	2,259,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,976,800.00	1,118,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,357,832.00	2,465,516.00
210404	Ном, хэвлэл	4,820,540.00	561,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,208,580.00	3,528,820.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>631,900.00</b>	<b>924,600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	631,900.00	245,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	679,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,920,000.00</b>	<b>4,721,000.00</b>
210604	Урсгал засвар	9,920,000.00	4,721,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,009,200.00</b>	<b>611,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,009,200.00	611,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,916,500.00</b>	<b>13,541,886.70</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,916,500.00	13,541,886.70
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,983,260.00</b>	<b>36,553,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,583,600.00	30,733,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	399,660.00	5,819,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>462,219,358.74</b>	<b>199,874,180.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>462,216,911.00</b>	<b>199,237,643.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	30,428,720.00	35,080,293.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	95,700,400.00	101,365,850.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	126,009,700.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	169,235,091.00	61,791,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,843,000.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,447.74</b>	<b>636,537.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,447.74	636,537.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,626,130,779.83	4,498,948,281.20	-2,141,220,230.37	3,983,858,830.66
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,626,130,779.83	4,498,948,281.20	-2,141,220,230.37	3,983,858,830.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,626,130,779.83	4,498,948,281.20	-2,141,220,230.37	3,983,858,830.66
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,343,527,977.87	00.00	-1,343,527,977.87
D08	Тайлант үеийн үр дүн	872,575,000.00	00.00	-322,815,266.07	549,759,733.93
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,705,779.83	3,155,420,303.33	-2,464,035,496.44	3,190,090,586.72

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,050,009,500.00	2,050,008,452.26	1,902,983,300.00	1,901,175,023.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,050,009,500.00	2,050,008,452.26	1,902,983,300.00	1,901,175,023.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,618,220,900.00	1,618,220,261.26	1,738,819,900.00	1,737,017,673.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,178,387,500.00	1,178,687,499.26	1,226,302,100.00	1,224,523,837.00
210101	Үндсэн цалин	946,543,900.00	950,277,607.26	994,458,500.00	970,343,248.00
210102	Нэмэгдэл	159,888,000.00	160,480,992.00	159,888,000.00	182,224,989.00
210104	Урамшуулал	71,955,600.00	67,928,900.00	71,955,600.00	71,955,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	132,077,500.00	132,077,500.00	145,842,000.00	145,841,800.00
210201	Тэтгэврийн даатгал	85,685,400.00	132,077,500.00	97,228,100.00	97,227,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,278,400.00	00.00	12,153,500.00	12,153,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,598,000.00	00.00	9,722,800.00	9,722,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,319,600.00	00.00	2,430,600.00	2,430,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,196,100.00	00.00	24,307,000.00	24,307,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	262,364,400.00	262,364,400.00	332,248,400.00	332,248,400.00
210301	Гэрэл, цахилгаан	14,158,500.00	12,512,128.00	12,978,900.00	14,137,600.00
210302	Түлш, халаалт	230,705,900.00	230,380,302.00	282,991,500.00	282,985,385.00
210303	Цэвэр, бохир ус	17,500,000.00	19,471,970.00	36,278,000.00	35,125,415.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,730,100.00	16,430,002.00	9,943,700.00	9,933,336.00
210401	Бичиг хэрэг	3,631,800.00	3,066,250.00	3,286,700.00	2,259,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,976,800.00	1,976,800.00	1,554,800.00	1,118,400.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,724,700.00	2,357,832.00	1,975,800.00	2,465,516.00
210404	Ном, хэвлэл	4,800,100.00	4,820,540.00	1,184,200.00	561,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элгэдэх, ахуйн эд зүйлс	4,596,700.00	4,208,580.00	1,942,200.00	3,528,820.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	631,900.00	631,900.00	924,600.00	924,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	631,900.00	631,900.00	327,000.00	245,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	597,600.00	679,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,920,000.00	9,920,000.00	4,721,000.00	4,721,000.00
210604	Урсгал засвар	9,920,000.00	9,920,000.00	4,721,000.00	4,721,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,009,200.00	1,009,200.00	617,000.00	611,000.00
210702	Дотоод албан томиллолт	1,009,200.00	1,009,200.00	617,000.00	611,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,316,700.00	3,316,500.00	1,405,900.00	1,398,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,316,700.00	3,316,500.00	1,405,900.00	1,398,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,783,600.00	13,783,260.00	16,815,200.00	16,815,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,383,600.00	13,383,600.00	10,995,500.00	10,995,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	399,660.00	5,819,700.00	5,819,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	431,788,600.00	431,788,191.00	164,163,400.00	164,157,350.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	431,788,600.00	431,788,191.00	164,163,400.00	164,157,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	95,700,400.00	95,700,400.00	101,366,300.00	101,365,850.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	126,009,700.00	126,009,700.00	00.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	169,235,500.00	169,235,091.00	61,791,500.00	61,791,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,843,000.00	40,843,000.00	1,005,600.00	1,000,000.00

**Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,050,009,500.00	2,050,008,452.26	1,902,983,300.00	1,901,175,023.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,044,909,500.00	2,044,907,052.26	1,898,883,300.00	1,898,246,763.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,044,909,500.00	2,044,907,052.26	1,898,883,300.00	1,898,246,763.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	5,100,000.00	5,101,400.00	4,100,000.00	2,928,260.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,100,000.00	5,101,400.00	4,100,000.00	2,928,260.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	2,356.00	2,356.00	00.00	00.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	139.00	139.00	00.00	00.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	109.00	109.00	109.00	109.00
620003	Үйлчлэх ажилтан	29.00	29.00	29.00	29.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	2,077.00	2,077.00	2,127.00	2,127.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦА</b>	2,077.00	2,077.00	2,127.00	2,127.00
630001	Төрийн өмчигч ЕБС	2,077.00	2,077.00	2,127.00	2,127.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>139.00</b>	<b>139.00</b>	<b>139.00</b>	<b>139.00</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	110.00	110.00	110.00	110.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	29.00	29.00	29.00	29.00